**ОРХОН АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 02 өдөр    Дугаар 13/06    Эрдэнэт

Газрын харилцааны талаар
2023 онд баримтлах үйл ажиллагааны
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Газрын харилцааны талаар 2023 онд баримтлах үйл ажиллагааны чиглэлийг нэгдүгээр, аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид шинээр эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус батлагсугай.

2.Энэхүү тогтоолын биелэлтийн явцыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд хагас жилээр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга (С.Батжаргал )-д даалгасугай.

ДАРГА    Д. МӨНХБАТ

C:My documents/togtool
079110337

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12
дугаар сарын 01-ний өдрийн Ээлжит XIII хуралдааны
13/06 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

# ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР 2023 ОНД БАРИМТЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

| № | Дунд, богино хугацааны бодлогын зорилт | Арга хэмжээ | Хэмжих нэгж | 2022 оны суурь түвшин | Хүрэх түвшин, үр дүн | Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая.төг/ | Үндсэн хэрэгжүүлэгч | Хамтрах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| НЭГ. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР: | | | | | | | | |
| 1 | ТЖҮЧ 3.6.1<br>ЗДҮАХ 5.1.1.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үе шатны төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх | хувиар | Төлөвлөгөө батлагдсан байна. | Төлөвлөгөөний 10%-ийг хэрэгжүүлсэн байна. | - | ГХБХБГ | Сумдын ЗДТГ |
| 2 | ТЖҮЧ 3.6.2<br>ЗДҮАХ 5.1.2.1 | Аймгийн хэмжээнд гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулан хаягийн цахим системд оруулах | тоогоор | 18434 нэгж талбар бүртгэгдсэн. | 6000 нэгж талбар шинээр бүртгэсэн байна | - | ГХБХБГ | ХЗА<br>ХББЗА |
| 3 | ТЖҮЧ 3.6.3<br>ЗДҮАХ 5.1.3.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч, байнгын шинжээчээр баталгаажуулах | тоогоор | 900 нэгж талбар баталгаажсан. | 500 нэгж талбар шинээр баталгаажуулсан байна. | - | ГХБХБГ | Сумдын ЗДТГ |
| 4 | ТЖҮЧ 3.6.3<br>ЗДҮАХ 5.1.3.2 | Жаргалант сумын бэлчээрийн газрын доройтлыг сайжруулах арга | Га-р | 7128.8 га газар байна | 1000.0 га газрыг нь сайжруулсан байна. | ОНТХ | ГХБХБГ | Жаргалант сумын ЗДТГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авах ажлыг зохион байгуулах | | | | | | |
| 5 | ТЖҮЧ 3.6.4<br>ЗДҮАХ 5.1.4.1 | Геодезийн тулгуур сүлжээ цэг, тэмдэгтийг сэргээх, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулан улсын нэгдсэн санд бүртгэх. | тоогоор | 109 цэг, тэмдэгт бүртгэлтэй байна. | 33 цэгийн тоо шинээр нэмэгдсэн байна. | - | ГХБХБГ | Тусгай зөвшөөрөлтэй ААН |
| 6 | ТЖҮЧ 3.6.1 | www.egazar.gov.mn цахим системийн үйлчилгээг иргэд өөртөө үйлчлэх ухаалаг /киоск/ төхөөрөмж авах, нэвтрүүлэх. | Тоогоор | 0 | 1 | 50.0 | ГХБХБГ | ХБТХОХ |
| 7 | - | Төрийн байгууллагад шинээр газар эзэмшүүлэх асуудлыг хөрөнгө оруулалтын асуудалтай нь уялдуулан тухай бүр нь шийдвэрлэх | тоогоор | 4 | Тухай бүр | - | ГХБХБГ | Аймгийн ЗДТГ |
| 8 | - | Салбарын хууль тогтоомжийг сурталчлах | тоогоор | 5 | 9 | - | ГХБХБГ | Баян-Өндөр сумын ЗДТГ |
| 9 | - | Газраа зориулалтын дагуу 2 жил ашиглаагүй зөрчил гаргасан иргэн, аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг хүчингүй болгох. | тоогоор | - | Тухай бүр | | ГХБХБГ | Аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ |
| ХОЁР.БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР: | | | | | | | | |
| 1 | ТЖҮЧ 3.6.1<br>ЗДҮАХ 5.2.2 | Хангайн бүсийн тулгуур төв Эрдэнэт хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын гүйцэтгэгчтэй хамтран ажиллах, орон нутгийн хот | Хувиар | Ажлын даалгавар боловсруулсан байна. | Хамтран ажиллах, мэдээллээр хангасан байна. | УТХ | ХОХБТХ | ХББЗА ГХБХБГ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулалтын суурь судалгаа мэдээллээр хангах | | | | | | |
| 2 | ТЖҮЧ 6.2.3<br>ЗДҮАХ4.1.9.2 | Орон сууцны хороолол доторх нийтийн эзэмшлийн зам, талбай, инженерийн дэд бүтэц, гэрэлтүүлгийн мэдээллийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх. | тоогоор | | | - | ГХБХБГ | ХОХБТХ<br>ХЗА |
| 3 | ТЖҮЧ 8.1.1<br>ЗДҮАХ 5.3.1 | Шинээр суурьшлын болон үйлдвэрийн зориулалтаар төлөвлөх боломжтой газрын байршил, хэмжээг тогтоож, төлөвлөлтийн зургийн даалгавар боловсруулах, санал өгөх батлуулах | тоогоор | 3 | 1 зургийн даалгавар боловсруулсан байна. | - | ГХБХБГ | ХОХБТХ<br>ХББЗА |
| 4 | ТЖҮЧ 2.5.2<br>ЗДҮАХ 5.5.1 | Дахин төлөвлөлтийн ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, судалгаа, тооцоо хамтран хэрэгжүүлэх. | тоогоор | 1 | 3 | - | ГХБХБГ | ХББЗА |
| 5 | - | Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг нэмж авах | тоогоор | 3 | 3 багаж нэмж авсан байна. | - | ГХБХБГ | Аймгийн ЗДТГ |

-- 000 --

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12
дугаар сарын 01-ний өдрийн Ээлжит XIII хуралдааны
....... дугээр тогтоолын хоёрдугаар хавсралт

# АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТААР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД ШИНЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

| № | Сум/Дүүрэг | Баг/Хороо | Төлөвлөлтийн нэгж талбар | Газрын байршил нэгж талбар бүрээр | Газрын нэр | Газрын зориулалт | Талбайн хэмжээ [m2] | Улирал I | Улирал II | Улирал III | Улирал IV |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баян-Өндөр | 14-р баг, Говил | 2996739 | X=435616.10 Y=5434115.27<br>X=435623.03 Y=5434060.81<br>X=435678.63 Y=5434066.60<br>X=435656.01 Y=5434132.52<br>X=435616.10 Y=5434115.27 | Илгээлт | 2201: 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц | 3045 | + | + | + | + |
| **21401002: ИААНБ дуудлага худалдаагаар эзэмшүүлэх** | | | | | | | | | | | |
| **№** | **Сум/Дүүрэг** | **Баг/Хороо** | **Төлөвлөлтийн нэгж талбар** | **Газрын байршил нэгж талбар бүрээр** | **Газрын нэр** | **Газрын зориулалт** | **Талбайн хэмжээ [m2]** | **Улирал I** | **Улирал II** | **Улирал III** | **Улирал IV** |
| 1 | Баян-Өндөр | 2-р баг, Оюут | 2996737 | X=432417.23 Y=5431134.21<br>X=432447.50 Y=5431082.40<br>X=432473.40 Y=5431097.53<br>X=432443.14 Y=5431149.34<br>X=432417.23 Y=5431134.21 | A1001 урд | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 1800 | + | + | + | + |
| 2 | Баян-Өндөр | 2-р баг, Оюут | 2996738 | X=432512.22 Y=5431189.69<br>X=432542.48 Y=5431137.88<br>X=432577.17 Y=5431158.14<br>X=432577.18 Y=5431227.63<br>X=432512.22 Y=5431189.69 | A1001 урд | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 3462 | + | + | + | + |
| 3 | Баян-Өндөр | 13-р баг, Баянцагаан | 2996740 | X=438715.79 Y=5434615.07<br>X=438727.32 Y=5434594.60<br>X=438755.19 Y=5434610.30<br>X=438743.72 Y=5434630.77<br>X=438715.79 Y=5434615.07 | Төмөр замын урд | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 752 | + | + | + | + |
| 4 | Баян-Өндөр | 1-р баг, Зэст | 3016757 | X=431524.19 Y=5431897.70<br>X=431554.19 Y=5431897.70<br>X=431554.19 Y=5431931.04<br>X=431524.19 Y=5431931.04<br>X=431524.19 Y=5431897.70 | Зэст баг, Өндөрлөгийн ард | 2111: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 1000 | + | + | + | + |